

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар

2022 оны хагас жилийн байдлаар 2022.05.20

Шийд вэр Д/д	Заал т Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ :	Хэрэгжилтын явц	Өери йн үнэлг ээ	Үнэлгээний тайлбар
1	2	3	4	5	6	7	8
МУ-ын хууль							
1	1	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчийн сургалт, нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж батлуулах	Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний 2021-2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж Тамгын газрын даргын 2022 оны А07 тоот тушаалаар баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг 91.3 хувийн биелэлттэй гүйцэтгэсэн. Төлөвлөгөөний хүрээнд албан хаагчдын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх зорилгоор 10 удаагийн дотоодын мөн бусад байгууллагаас 3 удаагийн сургалтыг зохион байгуулан, давхардсан тоогоор 200 албан хаагч хамрагдсан. Мөн 3 албан хаагчид дотоод журмын дагуу 1,250,0 төгрөгийн дэмжлэг тусламж үзүүлэн, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор 27 албан хаагчдад 680,0 төгрөгийн витаминжуулалтын багц олгосон.	100	
2	2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аян зохион байгуулах	Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны жилийн ажлын төлөвлөгөөнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх "Хөршийн холбоо" аян зохион байгуулахаар тусгагдсан бөгөөд тус арга хэмжээг 2022.06 сард зохион байгуулахаар удирдамж төлөвлөгөөг гаргаж батлуулсан. Сумын ГХУСАЗСЗөвлөлөөс 1,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.	30	Төлөвлөгөө гаргаж батлуулсан 6-р сард хийхээр төлөвлөсөн.

3	<p>18.1.2. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.)</p>	<p>2022 оны төсөвт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах төсвийг батлуулах</p>	<p>Сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар сумын гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд 13,0 сая тусгаж батлуулсан.</p>	70	Хэрэгжих шатандаа
4	<p>18.1.3. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.)</p>	<p>Түр хамгаалах байрны үйл ажиллагааг сайжруулах, хохирогчдод сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх</p>	<p>Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчлэх түр хамгаалах байр нь 2022 оны хагас жилийн байдлаар 13 иргэнд аюулгүй байдлын хамгааллын үйлчилгээ үзүүлж сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.</p>	70	Хэрэгжих шатандаа
5	<p>19.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.)</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх чиглэлээр хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах</p>	<p>Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг бууруулах зорилгоор 6 арга хэмжээ төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тулгамдсан үйлчилгээг үзүүлэх, Архины эмчилгээнд иргэдийг хамруулах, Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүрээнд аймгийн Цагдаагийн байгууллагатай хамтран 6 удаагийн хяналт шалгалтыг хийж давхардсан тоогоор 2456 иргэнийг хамруулсан. Үр дүн: Ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 73,6 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	70	Хэрэгжих шатандаа
6	<p>19.1.2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж,</p>	<p>Төлөвлөгөө гаргаж батлуулах,</p>	<p>Хамтарсан багийн төлөвлөгөөт хурлыг 5 удаа зохион байгуулж 31 асуудлыг хэлэлцэн 100 хувь</p>	70	Хэрэгжих шатандаа

		тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	хамтарсан багийн гишүүдийг чадавжуулах	шийдвэрлэсэн. Хамтарсан багийн гишүүдийг чадавжуулах "Гэр бүлийн хүчирхийллийн хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдийг чадавжуулах сургалт"-ыг 2 удаа зохион байгуулж хамтарсан багийн 16 гишүүнийг хамруулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 73,6 хувийн биелэлттэй.		
	7	19.1.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цагийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Түр хамгаалах байранд байрлуулсан хохирогч нарт үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх	Гэр бүлийн хүчирхийллийн насанд хүрээгүй хохирогч 12, насанд хүрэгч 1 иргэнийг хамгаалах байрны үйлчилгээнд хамруулан аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэн ажилласан. Хамтарсан багийн нарийн бичгийн дарга буюу нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн нь ганцаарчилсан өрөөтэй бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 60 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.	100	
	8	19.1.4. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвт тусгаж батлуулах	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг 2 удаа, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээг 2 удаа зохион байгуулан эрсдэл бүхий 31 гэр бүлд хүрч ажилласан. Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн төсөвт 10,0 сая төгрөг тусгаж батлуулсан.	100	

	9		<p>19.1.5. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)</p> <p>19.1.6 19.1.7 19.1.8</p>	<p>Хохирогчид үйлчилгээ үзүүлэх зардлыг орон нутгийн төсөвт тусгаж батлуулах</p>	<p>Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тулгамдсан үйлчилгээг үзүүлэх зардлын сумын соёл, спорт нийгмийн салбарт чиглэсэн арга хэмжээний хүрээнд 2,0 сая төгрөгийг тусгаж батлуулсан. Эхний хагас жилийн байдлаар 31 кэйс дээр хагас жилийн байдлаар ажиллан 2,0 сая төгрөгийг зарцуулсан. Үүссэн 31 кейсийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56 хувиар өссөн. Үүссэн 31 кейсийн 78 хувь нь ахуй орчны архидалтаас үүдэлтэй байна</p>	70	
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
3	10	<p>Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ</p>	<p>3.11. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх)</p>	<p>Зорилтот бүлгийн иргэдийн судалгааг гаргаж, эрүүл мэндийн эрт илрүүлгийн үзлэгт хамруулах арга хэмжээ авах</p>	<p>Сумын зорилтот бүлгийг 1923 иргэний судалгааг гаргаж өрхийн эрүүл мэндийн төв болон аймгийн нэгдсэн эмнэлэгт хүргүүлсэн. Сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгт 1923 иргэн хамрагдахаас 528 иргэн хамрагдаж 27,4 хувийн гүйцэтгэлтэй явна. "Энхтусдэм" өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран 5 дугаар сургуулийн 6-8 дугаар ангийн 65, 9-11 дүгээр ангийн 52, 2 дугаар сургуулийн 8-11 дүгээр ангийн 45 нийт 162 сурагчдад "ДЭЛХИЙ НИЙТЭЭРЭЭ СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ" өдрийг тохиолдуулан Хүүхэд болон өсвөр үеийнхэн сүрьеэ өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалтыг зохион байгуулсан.</p>	70	

Татварын ерөнхий
дүрэм - 8.1.

УИХ-ын тогтоол 2021.7.02 № 67, 1.1.м

4	11	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ	2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах; <i>2.2. ХЗДХТ 16 дахь шатны -ийн хөгжилтэй холбогдуулан аваж арга хэмжээний 2018.01.31. №02 -Э.Р</i>	Сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, зорилтот бүлгийн иргэдийн үзлэг шинжилгээнд хамруулах	05 дугаар сарын 20-ний байдлаар нийт 322 иргэнд БЗДХ шинжилгээ хийгдсэн. Үүнээс: • В, С вирус нь 190 иргэнээс /В-9, С-6 13/ • ДОХ/Тэмбүү 132 иргэнээс /Тэмбүү-10/ иргэн илэрч 100 хувь эмчилгээнд бүрэн хамруулсан. Жирэмсний хяналтад байгаа 46 эхэд БЗДХ өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөлийн талаар 2 удаагийн сургалт зохион байгуулж, гарын авлага материалаар хангасан.	70	
Ерөнхийлөгчийн зарлиг							
5	12	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туй 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Албан байгууллагын хаягыг хос бичгээр бичигтэй болгох, албан хаагчдад сургалт зохион байгуулах	Сүмбэр сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, сүмбэр сумын ЗДТГ, ИТХ нь гаднах хаягаа хос бичгээр бичсэн бөгөөд албан хаагчдын ерөөний хаягийг мөн хос бичгээр бичсэн. Байгууллагууд дотоод сургалтын төлөвлөгөөндөө монгол бичгийн сургалтыг тусгасан бөгөөд 300 албан хаагчийг хамруулан сургалт зохион байгуулж, албан хаагчдын түвшинг тогтоосон.	70	
	13		4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг	"Монгол бичигтэн" уралдаан зарлах, албан хаагчдын дунд сургалт зохион байгуулах, үзэсгэлэн гаргах	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, сурч судлах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлын тайланг аймгийн хэлний бодлогын зөвлөлд тайланг хүргүүлэн, арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллаж байна. Төрийн байгууллагын албан хаагчдын дунд "Монгол бичигтэн" уралдаан зохион байгуулахаар	30	

			иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.		төлөвлөж 1.0 сая төгрөгийг төсөвлөж батлуулсан.		
6	14	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Хяналт шалгалт зохион байгуулах, арга зүйн зөвөлгөөгөөр хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах	Сургуулиуд үдийн хоол хөтөлбөр болж хэрэгжиж байгаатай холбогдуулан багш ажилтан нарт хоол, түргэн хоол аливаа хүнсний бүтээгдэхүүн жижиглэн худалдаалахгүй болсон ба 3 сургууль орон тооны хоолны технологич, сургуулийн эмч нар хяналт тавьж ажиллаж байна. 1 сургуулийн баруун талд хүнсний дэлгүүр, цайны газар үйл ажиллагаа явуулдаг. 2 удаагийн хяналт шалгалт хийж арга зүйгээр хангаж ажилласнаар аливаа зөрчил дутагдал илрээгүй болно.	100	
	15		2. Амьд явах, амдрахын сайн сайхныг олон нийтэд сурталчилан таниулах, дээрх агуулага бүхий бүтээл, нэвтрүүлэг, мэдээлэлд ард иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг идэвхийлэн оролцохыг уриалсугай.	Иргэдэд мэдээлэл хүргэх сурталчлах, байгууллагын цахим хуудас болон фейсбүүк хаягаар иргэдэд мэдээлэл хүргэх	Аймгийн Цагдаагийн хэлтсийн хүүхдийн байцаагчтай хамтран гэмт хэргийн болон гэр бүлийн хүчирхийллийн, хүүхдийг хараа ханалтгүй орхисон хохирогч болсон хүүхэд, иргэдийн түр хамгаалах байранд байрлуулж сэтгэл зүйн эмчилгээ хийж аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Түр хамгаалах байранд эхний хагас жилийн байдлаар 12 хүүхэд, насанд хүрсэн 1 нийт 13 хохирогчийг 15 хоногийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үйлчилгээ үзүүлсэн 0- насны хүүхдүүд байсан. Иргэдийг соён гэгээрүүлэх зорилгоор үзүүлэн, гарын авлага 15 удаа бэлтгэж фейсбүүк хаягаар олон нийтэд хүргэсэн 1095 хандалт авсан байна. Шторик, контентууд хийж цахимаар иргэдэд хүргэх ажлууд хийгдэхээр бэлтгэгдэж байна. Үр дүн: 12 хүүхдийг хамгаалах байранд авч эрсдэлээс урьдчилан сэргийлсэн.	70	
	16		2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын	Архины хамааралтай иргэдийн судалгааг гаргах, эмчилгээнд хамруулах, архи согтууруулах ундааны хэрэглээ түүний хор хөнөөлийн талаар	"Боржигины оточ" эмнэлэгтэй гэрээ байгуулан Архины хэрэглээг бууруулах замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ахуйн хүрээний архидалтыг бууруулах, архины хамааралтай иргэд, түүний гэр бүлийн соён гэгээрүүлэх зорилгоор 3 удаагийн сургалт, уулзалт ярилцлагыг зохион байгуулж 43 иргэнийг хамруулсан. Сургалтад хамрагдсан иргэдээс архинаас гарах сайн дурын эмчилгээнд 16	70	

Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104
Төр бичиг 2019-58. 1.2, 1.6, 1.7, 1.8, 2.

			байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	иргэний хамруулсан 15 иргэн бүрэн гарсан. 7-р сард архины хамааралтай иргэдийн дунд "Таныг сонсоё" уулзалт ярилцлага зохион байгуулахаар төлөвлөөд байна. Үр дүн: Архины хамааралтай 15 иргэн архинаас бүрэн гаргасан.		
<p><i>Засгийн газрын гишүүн нод. 0302-43. 1.3, 1.4, 1.8, 2</i></p> <p align="center">ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл</p>							
7	17	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03	1.1. Орон нутагт ажиллаж буй газар хөдлөлт бүртгэх станц боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, үйл ажиллагааг нь олон улсын түвшинд хүргэхэд гадаадын мэргэжлийн тэргүүлэх байгууллагуудтай хамтарч ажиллах, газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох, төв суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлтэй нутаг дэвсгэрт барилгажуулах боломжтой газрыг тодорхойлох арга хэмжээ авах, (Аймаг, нийслэлийн Засаг дарга, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв)	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, ЕЗМА-ийн гишүүдийг хэсэгчилсэн сургалтад хамруулж чадавхжуулах	ЗГ-н 339-р тогтоолоор баталсан захирамжийн дагуу 4-р сард Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож, сумын ерөнхий зориулалтын Мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээнд гал түймрийн аюул, газар хөдлөлтийн үеийн дадлага сургуулилтын сургалтад 24 ажилтан албан хаагч хамрагдсан. Аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн гишүүдэд гамшгаас хамгаалах чиглэлээр ОБГазар дээр 3-р сард хийгдсэн "Орон нутагт эрсдлийн үнэлгээ хийх" сургалтанд 2 албан хаагч хамруулж чадавхжуулсан. Үр дүн: Гамшгаас хамгаалах бэлэн байдал хангагдаж, ЕЗМА-ийн томилгоот бүрэлдэхүүнийг чадавхжуулсан.	100	
<p align="center">ЗГ-ын тогтоол</p>							
8	18	Төлөвлөгөө батлах тухай 2021-01-20 Дугаар 2021_18	2. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутгийн жил бүрийн холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга,	Хоол үйлдвэрлэл явуулж буй сургуулиудад шалгалт хийх, зөрчил дутагдлыг арилгуулах	Ерөнхий боловсролын 1,2,5-р сургуулиуд хоол үйлдвэрлэлийг хэрэгжүүлж байгаа бөгөөд хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Хоолны технологич, мэргэжлийн тогоочоор бүрэн хангагдсан. 1,2,5-р сургуулийн хоол үйлдвэрлэлд 2 удаагийн хяналт шалгалт хийж, удирдлага арга зүйгээр хангаж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан.	100	

			холбогдох төрийн байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.				
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
9	19	2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69	Ү... Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав.		Е-mongolia системээр 522 иргэн үйлчлүүлсэн 28 төрлийн лавлагааг 392 оршин суугаа хаягийн тодорхойлолтыг 130 иргэнд олгосон. Олгосон лавлагааны 30 хувь нь оршин суугаа хаягын лавлагаа эзэлж байна. Цахимаар ирсэн 3 хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь бүрэн шийдвэрлэж хариу өгсөн. Егр системд 138 албан бичиг ирсэн үүнээс шийдвэрлэсэн 79, судлагдаж байгаа 22, эргэн танилцах 1, хугацаа дөхсөн 2, хугацаа хэтэрсэн 1, буцаасан 25 албан бичиг байна. Нийт 26 албан хаагч егр системийг өдөр тутамд бүрэн ашиглаж хэвшсэн. Сумын Засаг даргаас олгодог Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг шинээр авах, сунгах үйлчилгээг Е-mongolia системд оруулсан. Тус үйлчилгээг 4 иргэн аж ахуй нэгж аваад байна.	70	
10	20	2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2021-06-23 Дугаар 2021_36	XII.11.3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих замаар тухайн орон нутгаас нийлүүлэх болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнээр үйлчлэх боломжийг судалж, шийдвэрлэх чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд;	Хоол үйлдвэрлэл явуулж буй сургуулиудад шалгалт хийх, зөрчил дутагдлыг арилгуулах	Ерөнхий боловсролын 1,2,5-р сургуулиуд хоол үйлдвэрлэлийг хэрэгжүүлж байгаа бөгөөд хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Хоолны технологич, мэргэжлийн тогоочоор бүрэн хангагдсан. 1,2,5-р сургуулийн хоол үйлдвэрлэлд 2 удаагийн хяналт шалгалт хийж, удирдлага арга зүйгээр хангаж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан.	100	
	21		XII.11.4. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, шаардлага хангасан зориулалтын байргүй сургуульд шинээр зориулалтын байр барих		Сумын 1,2,5-р сургуулиуд хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын шшаардлага хангасан зориулалтын байранд хоол үйлдвэрлэл явуулж байна. Байргүй сургууль байхгүй.	100	

			<p>ажлын зураг төслийг 2021 онд багтаан боловсруулж, 2022 оноос улсын төсөвт тусгуулах, төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн хоол үйлдвэрлэлийн зориулалт бүхий талбайг бусдад ашиглуулсны төлбөрөөс төвлөрүүлэх орлогыг 100 хувь тухайн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрны засвар, тоног төхөөрөмжид зарцуулах боломжийг судлан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>			
11	22	<p>2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58</p>	<p>XII.6. Газар хөдлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох сайд, дарга нарт даалгав: 1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 17/12 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2018 оны н/206 дугаар тогтоолын хавсралтад заасан газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгыг тэргүүн ээлжид буулгах, шинээр барих ажлыг судлан танилцуулахыг</p>	<p>Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, ЕЗМА-ийн гишүүдийг хэсэгчилсэн сургалтад хамруулж чадавхжуулах</p>	<p>ЗГ-н 339-р тогтоолоор баталсан захирамжийн дагуу 4-р сард Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож, сумын ерөнхий зориулалтын Мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх арга хэмжээнд гал түймрийн аюул, газар хөдлөлтийн үеийн дадлага сургуулилтын сургалтад 24 ажилтан албан хаагч хамрагдсан. Аймгийн гамшгийн эрсдлийг бууруулах зөвлөлийн гишүүдэд гамшгаас хамгаалах чиглэлээр ОБГазар дээр 3-р сард хийгдсэн "Орон нутагт эрсдэлийн үнэлэгээ хийх" сургалтад 2 албан хаагч хамруулж чадавхжуулсан. Үр дүн: Гамшгаас хамгаалах бэлэн байдал хангагдаж, ЕЗМА-ийн томилгоот бүрэлдэхүүнийг чадавхжуулсан.</p>	100

	23		<p>XII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн зх үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.</p>	<p>Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвт тусгаж батлуулах</p>	<p>Сумын гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 20,0 сая төгрөгийг төсөвлөж орон нутгийн төсөвт тусгаж батлуулсан.</p>	100	
13	24	<p>2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23 Дугаар 2022_12</p>	<p>X.5. 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр</p>		<p>Энэ оны эхний 5 сарын байдлаар Сумын Засаг дарга түүний Тамгын газарт нийт-96 өргөдөл, гомдол санал хүсэлт ирсэн. Нийт өргөдлийн 44 өргөдөл шийдвэрлэх шатанд, 52 өргөдлийг бүрэн шийдвэрлэж 54.1%-ийн гүйцэтгэлтэй байна. Нийт 315 албан бичиг ирснээс 64 нь хариутай бичиг ба хугацаанд нь 61 албан бичгийг шийдвэрлэн, 3 албан бичгийн хугацааг хоцроон шийдвэрлэсэн байна. Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан 1 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өгсөн.</p>	70	

			үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.				
ЗГ-ын албан даалгавар							
14	25	Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03	1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх;	Төрийн үйлчилгээний опериаторыг томилох, сургалтад хамруулах, төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдэд сурталчлах	2022 оны 01 дүгээр сараас эхлэн төрийн үйлчилгээний опериаторыг томилон ажиллуулж байна. Төрийн үйлчилгээний опериатор болон мэдээлэл технологийн ажилтанг 1 удаагийн сургалтад хамруулсан. Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн хүргэх шуурхай байдлыг хангах зорилгоор Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөлийг E-mongolia системд оруулсан. Системээр 2 иргэн, 3 хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн.	70	
	26	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2	1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх;	E-mongolia системээс иргэдэд лавлагаа олгох, сурталчлах;	E-mongolia системээр 522 иргэн үйлчлүүлсэн 28 төрлийн лавлагааг 392 иргэнд олгосон. Олгосон лавлагааны 66,5 хувь нь оршин суугаа хаягын лавлагаа зээлж байна. Цахимаар ирсэн 3 хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн. E-mongolia системийг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд 625 иргэнд гарын авлага материал тарааж 169 иргэний гар утсанд апп татан өгч арга зүйгээр хангаж ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад E-mongolia системээс лавлагаа авах иргэдийн тоо 69,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100	
	27		1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах;	Төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах	Албан хэрэгцээнд Тамгын газрын дарга, нягтлан бодогч, Санхүү албаны дарга, төрийн үйлчилгээний опериатор нар тоон гарын үсэг зээмшиж байна.	100	
	28		1.6. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах;		Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл олгоход Улсын тэмдэгтийн хураамж 250,0 төгрөг буюу нийт 1250,0 төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.	100	
	29		1.7. ХУР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн	Коллпоро үйлчилгээг нэвтрүүлэх, иргэдийн санал хүсэлтийг утсаар авах боломжийг бүрдүүлэх	Төрийн үйлчилгээг цахимаар авахад шаардлагатай мэдээлэл, арга зүйн зөвлөгөөг иргэдэд өгөх, E-mongolia аппликейшн гар утсандаа татах, E-mongolia порталаас хэрхэн төрийн үйлчилгээг өөрсдөө авах арга зүйн зөвлөгөөг өгч, төрийн мэдээллийн Хур системийг ашиглан иргэд, байгууллагуудад төрийн	70	

		газартай нягт хамтран ажиллах;		байгууллагын 28 төрлийн 522 лавлагаа тодорхойлолтуудыг гарган өгч үйлчилгээ үзүүлж байна. E-Mongolia системд 2022 оны эхний хагас жилийн байдлаар Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгалт хийх үйлчилгээг цахимаар авах боломжтой болоод байна. Мөн сумын хэмжээнд Коллпоро үйлчилгээг нэвтрүүлж иргэдийн санал хүсэлтийг хүлээх авах 70543232 утас тогтмол ажиллуулж тухайн утаснаас Хөдөлмөр халамжийн үйлчилгээ, Улсын бүртгэлийн үйлчилгээ, Хог хаягдал тээвэрлэлтийн үйлчилгээг холбосон. 70543232 дугаар утсаар ХХҮГ-тай 10, УБХ-7, ГХББХГ-тай 9, опериатортой 13 удаа холбогдох мэдээлэл авсан байна.		
30		1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах;	Төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд мэдээллэх	Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар www.sumber.gs.gov.mn сайт болон олон нийтийн <u>Сүмбэрийн мэдээ</u> , <u>Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар</u> , <u>Хоггүй Сүмбэр зэрэг Фэйсбүүк</u> , орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан иргэд олон нийтэд сурталчлах ажлын цаг тухай бүрд нь хийж ажиллаж байна.	100	
31		1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг "Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем"-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох.	ERP" системийн ашиглалтыг сайжруулах, албан бичиг хэргийн дэд системээр дамжуулан хэрэглэх	Төрийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн "ERP" системийг бүрэн нэвтрүүлсэн. "ERP" системийн албан бичиг хэргийн дэд системээр дамжуулан байгууллагад 138 албан бичиг ирсэн үүнээс шийдвэрлэсэн 79, судлагдаж байгаа 22, эргэн танилцах 1, хугацаа дөхсөн 2, хугацаа хэтэрсэн 1, буцаасан 25 албан бичиг байна. Байгууллага хооронд албан бичгийн хариуг ERP болон цаасаар хүргүүлж байна.	70	

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

/2022 оны эхний хагас жилийн байдлаар/

		Үүнээс							
		Монгол Улсын хууль	УИХЕХ-ын тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	
Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо		14	2	2	2	1	1	4	1
Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо		31	9	2	5	1	1	6	7
Хэрэгжилтийн үнэлгээ	Бүрэн хэрэгжсэн	100%	14	3		1	1	4	4
	Хэрэгжих шатанд	70 %	15	5	2	3		2	3
	Хэрэгжилт хангалтгүй	30 %	2	1		1			
	Хэрэгжээгүй	0 %							
Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй									
Биелэлтийн хувь		84,3	75,5	70	68	100	100	90	87,1

ТАЙЛАНД ХШҮ ХИЙЖ, ХЯНАСАН:
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ДОТООТ АЖИЛ ХАРИУЦСАН МЭРЭГЖИЛТЭН



П.НАРАНМАНДАХ

Э.САРНАЙ